

## ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

### “ОРХОН АЙМГИЙН 2021 ОНЫ ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ” АУДИТЫН ТАЙЛАН



**ТУСГАЙ ШИЛЖҮҮЛГИЙН БАЙГУУЛЛАГАД ОЛГОХ ТОГТМОЛ ЗАРДЛЫН ТӨСВИЙГ БОДИТОЙ ТӨЛӨВЛӨӨГҮЙ,  
ЗАРЛАГЫН ГҮЙЛГЭЭНД ТАВИХ ХЯНАЛТ ДУТМАГ БАЙНА.**

**Орхон аймаг  
2022 он**

АГУУЛГА

	Товчилсон үгийн жагсаалт.....	3
<b>Аудитын тайланг бэлтгэсэн:</b>	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, шалгуур үзүүлэлт, аудит хийх үндэслэл:	4
<b>Орхон аймаг дахь Төрийн аудитын газар:</b>	<b>БҮЛЭГ 1. Орон нутгийн төсөвт 2 удаа тодотгол хийж, орлогыг анх батлагдсан төсвөөс 1,740.0 сая төгрөгөөр, хөрөнгө оруулалтын зардлыг 5,011.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэн тодотгожээ.</b>	6
	1.1 Сангийн яамнаас хянасан орлого зарлагын дүнгээс орлогыг 2,117.2 сая төгрөгөөр бууруулж, зарлагыг 5,308.2 сая төгрөгөөр нэмэгдүүлж орон нутгийн төсвийг баталжээ.	7
	1.2 Төсөвт 2 удаа тодотгол хийж хөрөнгө оруулалтын зардлыг 5,011.0 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн.	11
Дарга, тэргүүлэх аудитор: Ц.Нармандах	<b>БҮЛЭГ 2. Өмнөх оны аудитаар тусгай шилжүүлгийн байгууллагын тогтмол зардлыг өмнөх оны гүйцэтгэлтэй уялдуулан бодитой төлөвлөж байх зөвлөмж хүргүүлсэн боловч хэрэгжилт хангагдаагүй, төрийн сангийн гүйлгээг бөөн дүнгээр хянаснаас шалтгаалж нэг ижил дүнтэй гүйлгээ 2 давхардаж гарсан.</b>	12
Аудитын менежер: Б.Эрдэнэ Аудитор: Т.Болормаа	2.1 Орон нутгийн татварын орлого 9,939.8 сая төгрөгөөр давж биелсэн бол бусад орлого 194.0 сая төгрөгөөр тасарсан байна.	13
<b>2022 оны 04 дүгээр сар</b>	2.2 Тусгай шилжүүлгийн байгууллагын тогтмол зардлыг өмнөх оны гүйцэтгэлтэй уялдуулан бодитой төлөвлөж байх зөвлөмж хүргүүлсэн боловч хэрэгжилт хангагдаагүй, төрийн сангийн гүйлгээг бөөн дүнгээр хянаснаас шалтгаалж нэг ижил дүнтэй гүйлгээ 2 давхардаж гарсан.	14
Аудитын тайлан дүгнэлттэй холбоотой асуудлаар 70353088, 70350757, 70355805 дугаарын утсаар харилцана уу.	<b>БҮЛЭГ 3. Ковид цар тахлаас шалтгаалан нэмэлт санхүүжилтийн дансны орлого болон хөрөнгө оруулалтын зардлууд өмнөх оноос буурсан үзүүлэлттэй байна.</b>	20
Уг тайланг УАГ-ын цахим хуудаснаас үзнэ үү. /www.audit.mn/	3.1 Аймгийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний биелэлт 97.4 хувийн биелэлттэй байна.	20
	3.2 2020 онтой харьцуулахад нэмэлт санхүүжилтийн дансны орлого 485.6 сая, зардал 490.6 сая төгрөгөөр тус тус буурсан байна..	21
<b>Хаяг:</b> Орхон аймаг дахь Төрийн аудитын газар Баян-Өндөр сум, Хүрэнбулаг баг, Нутгийн удирдлагын ордон	<b>Дүгнэлт Зөвлөмж Тэргүүлэх аудиторын тушаал</b>	22 23
Орхон аймаг		

## ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

УИХ	Улсын Их Хурал
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
АИТХ	Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ҮАГ	Үндэсний аудитын газар
АОУС	Аудитын олон улсын стандарт
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ОНХНС	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан
ТӨЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
СТСХ	Санхүү төрийн сангийн хэлтэс
ҮХЭХ	Үл хөдлөх эд хөрөнгө
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
АТБӨЯХАТ	Авто тээвэр болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар
ТТАМ	Түгээмэл тархацтай ашигт малтмал
ОАТ	Орлогын албан татвар
ААН	Аж ахуй нэгж
ГБХЗХГ	Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар
ГХБХБГ	Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар
ТАХ	Төсөл арга хэмжээ
ХББЗА	Хот байгуулалт, барилга захиалагчийн алба
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
СХАА	Санхүүгийн хяналт, аудитын алба
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
ЗГНХ	Засгийн газрын нөөц хөрөнгө
ЗДНХ	Засаг даргын нөөц хөрөнгө
ТББ	Төрийн бус байгууллага
ЗД	Засаг дарга

**Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:**

Аудитыг Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4 дэх заалт, Орхон аймаг дахь төрийн аудитын газрын 2021 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөөний 2.4 дэх заалтыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэгт заасан төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийж гүйцэтгэлээ.

**Аудитын зорилт:**

Орхон аймгийн 2021 оны төсвийн гүйцэтгэл үнэн зөв илэрхийлэгдсэн эсэх талаар үндэслэлтэй баталгаагаар хууль тогтоох байгууллагыг хангахад энэхүү аудитын зорилт чиглэгдлээ. Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудит гүйцэтгэнэ. Үүнд:

- 2021 оны төсвийн орлого, зарлагын гүйцэтгэл,
- 2021 оны төсвийн орлогыг бүрэн төвлөрүүлсэн эсэх,
- 2021 оны батлагдсан төсвийг зориулалтын дагуу, үр дүнтэй зарцуулж буй эсэх,
- Нэмэлт төсвийн гүйцэтгэл түүний танилцуулга

**Аудитын хамрах хүрээ:**

Аудитыг Орхон аймгийн ТЕЗ-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний байдлаарх санхүүгийн тайлан тэнцэл, судалгаа, мэдээлэл болон бусад холбогдох баримт материалд тулгуурлан гүйцэтгэлээ.

**Аудитын арга зүй:**

Аудитыг гүйцэтгэхэд Аудитын Дээд байгууллагуудын олон улсын стандарт, арга зүйг баримтлан холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга, лавлагаа авах, тайлан баримт материалд тулган баталгаажуулалт, дүн шинжилгээ хийх зэрэг арга зүйг ашиглахын зэрэгцээ аудитын судалгаа, хөтөлбөр, горимын дагуу нотлох зүйл цуглуулж, дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа.

**Аудитад ашигласан шалгуур үзүүлэлтүүд:**

Дараах хууль эрхийн актыг аудитын шалгуур үзүүлэлтийн эх сурвалж болгон ашиглалаа. Үүнд:

- Монгол Улсын Үндсэн хууль
- Төсвийн тогтвортой байдлын тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Төрийн аудитын тухай хууль
- Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хууль
- Нийгмийн даатгалын сангийн 2021 оны төсвийн тухай хууль
- Нийгмийн даатгалын багц хуулиуд
- Эрүүл мэндийн даатгалын сангийн 2021 оны төсвийн тухай хууль
- Татварын багц хуулиуд
- Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хууль
- Аймгийн ИТХ-ын тогтоол

**Аудит хийх бүрэлдэхүүн:**

Аудитыг Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Нармандах удирдан, менежер Б.Эрдэнэ чанарын хяналт хийж, аудитор Т.Болормаа төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэв.

**Үндсэн мэдээлэл:**

Орхон аймгийн 2021 оны төсвийн орлого нь татварын ба татварын бус орлого, орлогын шилжүүлэг, төсөвт байгууллагуудын өөрийн орлогоос бүрдсэн бөгөөд уг эх үүсвэрээр аймаг, сумын ИТХ, ЗДТГ, баг, Засаг даргын нөөц сан, Орон нутгийн хөгжлийн сан, Нийгмийн халамжийн сан, орон нутагт хэрэгжүүлж байгаа Сум хөгжүүлэх сан, Байгаль хамгаалах сан, Эрдэнэт сан, орон нутгийн байгууллага, орон нутгийн өмчит үйлдвэрийн газар, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой төсвийн байгууллагууд, тусгай зориулалтын шилжүүлэгтэй ерөнхий боловсролын сургууль, хүүхдийн цэцэрлэг, Соёлын төв, Эрүүл мэндийн төв нийт аймгийн хэмжээгээр 96 байгууллага санхүүжүүлсэн байна.

Монгол Улсын 2021 оны Төсвийн тухай хуульд Орхон аймгийн 2021 оны орон нутгийн хөгжлийн сангаас олгох орлогын шилжүүлгийг 5,353.7 сая төгрөг, улсын төсөвт төвлөрүүлэх орлогыг 24,601.6 сая төгрөгөөр баталжээ.

Орхон аймгийн 2021 оны орлогын төлөвлөгөөг аймгийн ИТХ-ын 2020 оны 12 сарын 25-ны өдрийн А/805 дугаар тогтоолоор 67,406.6 сая төгрөгөөр төлөвлөж баталснаас татварын орлогыг 66,547.1 сая төгрөг, татварын бус орлогыг 859.5 сая төгрөгөөр тус тус баталсан байна.

**БҮЛЭГ 1. Орон нутгийн төсөвт 2 удаа тодотгол хийж, орлогыг анх батлагдсан төсвөөс 1,740.0 сая төгрөгөөр, хөрөнгө оруулалтын зардлыг 5,011.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэн тодотгожээ.**

**1.1 Сангийн яамнаас хянасан орлого зарлагын дүнгээс орлогыг 2,117.2 сая төгрөгөөр бууруулж, зарлагыг 5,308.2 сая төгрөгөөр нэмэгдүүлж орон нутгийн төсвийг баталжээ.**

Орхон аймгийн төсвийн орлогыг сангийн яам дараах байдлаар хянасан хянасан байна. Үүнд:

Үзүүлэлт /сая төгрөг/	Суурь орлого /Санал/	Суурь орлого /Хянасан/	Зөрүү
<b>Орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлого</b>	<b>1</b>	<b>2</b>	<b>3=(2-1)</b>
Орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлого	58,323.8	69,523.8	(11,200.0)
Татварын орлого	55,461.0	66,661.0	(11,200.0)
<b>Орлогын албан татвар</b>	<b>34,960.0</b>	<b>34,960.0</b>	-
<b>Хувь хүний орлогын албан татвар</b>	<b>37,960.0</b>	<b>37,960.0</b>	-
Цалин хөдөлмөрийн хөлс, шагнал урамшуулал болон тэдгээртэй адилтгах орлого	33,000.0	33,000.0	-
Үйл ажиллагааны орлого	410.0	410.0	-
Хөрөнгийн орлого	2,650.0	2,650.0	-
Хөрөнгө борлуулсны 2%	900.0	900.0	-
Шууд бус / суутгагчийн хувь хүний орлого/	1,000.0	1,000.0	-
Хувь хүний орлогын албан татварын буцаалт	(3,000.0)	(3,000.0)	-
<b>Хөрөнгийн татвар</b>	<b>9,516.0</b>	<b>9,516.0</b>	-
Үл хөдлөх хөрөнгийн албан татвар	8,480.0	8,480.0	-
Бууны албан татвар	36.0	36.0	-
Авто тээвэр болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар	1,000.0	1,000.0	-
Бусад татвар	10,985.0	22,185.0	(11,200.0)
Улсын тэмдэгийн хураамж	440.0	440.0	-
ТХАМА-ны төлбөр	35.0	35.0	-
Хог хаягдлын хураамж	570.0	570.0	-
Газрын төлбөр	9,610.0	20,810.0	(11,200.0)
<b>Байгалын нөөц ашигласны төлбөр</b>	<b>330.0</b>	<b>330.0</b>	-
Ойн нөөц ашигласны төлбөр	10.0	10.0	-
Ус рашаан нөөц ашигласны төлбөр	320.0	320.0	-
<b>Татварын бус орлого</b>	<b>2,862.8</b>	<b>2,862.8</b>	-
Төсвийн байгууллагын өөрийн орлого	2,062.8	2,062.8	-
Хүү торгуулийн орлого	800.0	800.0	-

Орон нутгаас төсвийн орлогыг саналыг 58,323.8 сая төгрөгөөр хүргүүлэхэд Сангийн яам 69,523.8 сая төгрөгөөр хянасан байна.

Дээрхээс үзэхэд газрын төлбөрийн орлогыг 9,610.0 сая төгрөгөөр санал хүргүүлсэн боловч 11,200.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж 22,185.0 сая төгрөгөөр хянасан байна.

Аймгийн ИТХ-ын 2020 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн 02/05 дугаар тогтоолоор төсвийн орлогыг сангийн яамнаас хянасан 69,523.8 сая төгрөгөөс 2,117.2 сая төгрөгөөр бууруулж 67,406.6 сая төгрөгөөр баталсан байна.

**ОРХОН АЙМГИЙН 2021 ОНЫ ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**

Үзүүлэлт /сая төгрөг/	Аймгийн ИТХ 02/05 тогтоол	Аймгийн ИТХ 07 тогтоол	Аймгийн ИТХ 05/02	Зөрүү
<b>төсөвт төвлөрүүлэх орлого</b>	<b>1</b>	<b>2</b>	<b>3</b>	<b>4=(2-1)</b>
Орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлого	67,406.6	69,146.6	69,146.6	1,740.0
Татварын орлого	66,547.1	68,287.1	68,287.1	3,480.0
Цалин хөдөлмөрийн хөлс, шагнал урамшуулал болон тэдгээртэй адилтгах орлого	33,100.0	36,611.2	36,611.2	3,511.2
Үйл ажиллагааны орлого	265.0	265.0	265.0	-
Хөрөнгийн орлого	2,950.0	2,950.0	2,950.0	-
Хөрөнгө борлуулсны 2%	1,000.0	1,050.0	1,050.0	50.0
Шууд бус / суутгагчийн хувь хүний орлого/	700.0	650.0	650.0	(50.0)
Хувь хүний орлогын албан татварын буцаалт	(3,000.0)	(2,410.8)	(2,410.8)	(589.2)
Үл хөдлөх хөрөнгийн албан татвар	8,304.5	8,445.0	8,445.0	140.5
Бууны албан татвар	34.2	40.0	40.0	5.8
Авто тээвэр болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар	966.6	966.6	966.6	-
Бусад татвар	-	-	-	-
Улсын тэмдэгтийн хураамж	440.0	440.0	440.0	-
ТХАМА-ны төлбөр	30.0	24.8	24.8	(5.2)
Хог хаягдлын хураамж	570.0	570.0	570.0	-
Газрын төлбөр	20,876.8	18,375.4	18,375.4	(2,501.4)
Ус рашаан нөөц ашигласны төлбөр	310.0	310.0	310.0	-
<b>Татварын бус орлого</b>	<b>859.5</b>	<b>859.5</b>	<b>859.5</b>	<b>-</b>
Төсвийн байгууллагын өөрийн орлого	59.5	59.5	59.5	-
Хүү торгуулийн орлого	800.0	800.0	800.0	-

Төсөв батлагдсанаас хойш төсвийн тодотголыг 2 удаа хийсэн бөгөөд аймгийн ИТХ-ын 2021 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн 7 дугаар тогтоолоор орон төсөвт төвлөрүүлэх орлогыг 69,146.6 сая төгрөг, аймгийн ИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 05/02 дугаар тогтоолоор орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг 69,146.6 сая төгрөгөөр тус тус шинэчлэн баталсан.

Аймгийн ИТХ-ын 2020 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн 02/05 дугаар тогтоолоор төсвийн орлогыг 67,406.6 сая төгрөгөөр баталсан бол аймгийн ИТХ-ын 07, 05/02 дугаар тогтоолоор орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг 69,146.6 сая төгрөг болгож 1,740.0 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн байна.

Орон нутгийн төсөвт төвлөрөх тусламжийн орлого болон шилжих үлдэгдэл

№	Орлогын төрөл	Аймгийн ИТХ 02/05	Аймгийн ИТХ 07	Аймгийн ИТХ 05/02
<b>1</b>	<b>Тусламжийн орлогын дүн</b>	<b>46,009.6</b>	<b>47,235.2</b>	<b>47,591.2</b>
1	ОНХС-ын орлогын шилжүүлэг	5,091.5	5,353.7	5,353.7
2	Тусгай зориулалтын шилжүүлэг	40,861.6	38,736.9	42,180.9
3	Тусгай зориулалтаар санхүүжих байгууллагын өөрийн орлого	26.6	26.6	26.6
4	Эрүүл мэндийн даатгалын сангийн шилжүүлэг	29.9	3,117.9	29.9
<b>5</b>	<b>Урьд оны шилжих үлдэгдэл</b>	<b>15,917.6</b>	<b>15,791.1</b>	<b>15,791.1</b>
6	Урьд оны шилжих үлдэгдлээс санхүүжих	14,575.2	15,112.1	15,112.1
7	Урьд оны шилжих үлдэгдэл /ОНХС/	1,342.4	679.0	679.0
<b>8</b>	<b>Нийт орлогын дүн</b>	<b>61,927.2</b>	<b>63,026.3</b>	<b>63,382.3</b>

Орон нутгийн төсөвт төвлөрөх бусад орлогыг аймгийн ИТХ-ын 2020 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн 02/05 дугаар тогтоолоор 61,927.2 сая төгрөгөөр баталсан бол аймгийн

**ОРХОН АЙМГИЙН 2021 ОНЫ ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**

ИТХ-ын 2021 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн 7 дугаар тогтоолоор 1,099.1 сая төгрөгөөр нэмэгдүүлж 63,026.3 сая төгрөг болгосон бол аймгийн ИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 05/02 дугаар тогтоолоор 63,382.3 сая төгрөг болгон өөрчлөн баталсан байна.

Аймгийн төсвийн зарлагыг орон нутгаас Цэцэрлэгжүүлэлт ногоон байгууламжийн газар 472.4 сая, Нийтлэг үйлчилгээний албаны 706.9 сая төгрөгийг оруулаад доорх зардлуудыг нэмж 33,604.6 сая төгрөгийн зарлагын саналыг хүргүүлсэн байна.

№	Байгууллагын нэр	төсвийн санал	Сангийн яам хянасан	Зөрүү
		1	2	3= (2-1)
1	Аймгийн ИТХ	1,040.5	245.1	(795.4)
2	Сумдын ИТХ	403.2	185.3	(217.9)
3	Аймгийн ЗДТГ	3,532.4	1,787.1	(1,745.3)
4	Сумдын ЗДТГ	4,658.4	2,072.7	(2,585.7)
5	Хотын захирагчийн алба	297.4	182.7	(114.7)
6	Хот тохижуулах газар	5,400.7	1,886.3	(3,514.4)
7	Ойн анги	161.4	60.5	(100.9)
8	Байгаль орчин нөхөн сэргээх		2,000.0	2,000.0
9	Халамжийн сан	170.0	128.4	(41.6)
10	Санхүү хяналт аудитын алба	259.8	161.5	(98.3)
11	Орон нутгийн өмчийн газар	369.3	261.7	(107.6)
12	Цэцэрлэгийн ТШЗ-ийн тогтмол зардал	2,154.3	1,278.3	(876.0)
13	Боловсролын байгууллагын тогтмол зардал	2,723.3	1,636.1	(1,087.2)
14	ГБХЗХГ-ын тогтмол зарал	60.1	33.6	(26.5)
15	ГЗБГЗЗГ-ын ТЗШ-ийн тогтмол зардал	15.8	51.9	36.1
16	Анхан шатны эрүүл мэндийн төвийн тогтмол зардал	42.0	29.6	(12.4)
17	Соёлын байгууллагууд	2,112.6	1,829.1	(283.5)
18	Биеийн тамир спортын газрын тогтмол зардал	1,005.1	59.1	(946.0)
19	Замын сан	850.0	801.0	(49.0)
20	Мэдээлэл шуурхай удирдлагын төв	256.9	72.5	(184.4)
21	Байгаль орчныг хамгаалах газар	4,285.5	2,024.7	(2,260.8)
22	Хотын нийтийн тээвэр	2,436.0	1,201.2	(1,234.8)
23	Мал эмнэлгийн үйлчилгээ	78.0	26.0	(52.0)
24	Ахмадын хорооны төсөв	112.6	66.9	(45.7)
	<b>Нийт</b>	<b>32,425.3</b>	<b>18,081.3</b>	<b>-14,343.98</b>

Сангийн яам зарлагын саналыг 14,343.9 сая төгрөгөөр бууруулж 18,081.3 сая төгрөгөөр хянасан байна. Харин орон нутгийн төсвийн хүргүүлсэн саналаас Цэцэрлэгжүүлэлт ногоон байгууламжийн газар 472.4 сая, Нийтлэг үйлчилгээний албаны 706.9 сая, нийт 1,179.3 сая төгрөгийн төсвийг Сангийн яам ОНӨААТҮГ гэж үзэж төсвийг хянадаггүй байна.

Аймгийн ИТХ-ын 2020 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн 02/05 дугаар тогтоолоор төсвийн ерөнхийлөн захирагчид 23,389.5 сая төгрөгийн зарцуулах эрхийг олгосон байна.

**ОРХОН АЙМГИЙН 2021 ОНЫ ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**

№	Байгууллагын нэр	ИТХ-ын 2020.11.30 02/05	ИТХ-ын 2021.09.15 07	ИТХ-ын 2021.12.28 05/02	Зөрүү	
		1	2	3	4= (2-1)	5= (3-2)
1	Аймгийн ИТХ	1,098.8	1,151.2	1,151.2	52.40	-
2	Баян-Өндөр сумын төсөв	2,743.8	2,923.8	2,923.8	180.00	-
3	Аймгийн ЗДТГ	2,497.6	2,637.6	2,637.6	140.00	-
4	Жаргалант суманд олгох төсөв	1,459.2	1,451.5	1,455.9	(7.70)	4.4
5	Хотын захирагчийн алба	218.6	218.6	218.6	-	-
6	Хот тохижуулах газар	4,584.6	4,672.6	4,672.6	88.00	-
7	Ойн анги	99.3	99.3	99.3	-	-
8	Байгаль орчин нөхөн сэргээх	1,721.3	1,468.9	1,468.9	(252.40)	-
9	Халамжийн сан	128.4	128.4	128.4	-	-
10	Санхүү хяналт аудитын алба	195.4	195.4	195.4	-	-
11	Орон нутгийн өмчийн газар	294.9	308.4	308.4	13.50	-
12	Цэцэрлэгийн ТШЗ-ийн тогтмол зардал	1,255.0	1,367.0	1,365.4	112.00	(1.6)
13	Боловсролын байгууллагын тогтмол зардал	1,504.8	1,504.8	1,502.0	-	(2.8)
14	ГБХЗХГ-ын тогтмол зардал	23.2	23.2	23.2	-	-
15	ГХБХБГ-ын ТШЗ-ийн тогтмол зардал	11.4	11.4	11.4	-	-
17	Соёлын байгууллагууд	1,556.0	1,556.0	1,556.0	-	-
18	Биеийн тамир спортын газрын тогтмол зардал	23.5	23.5	23.5	-	-
19	Авто замын сан	1,397.9	1,263.1	1,263.1	(134.80)	-
20	Мэдээлэл шуурхай удирдлагын төв	127.3	131.2	131.2	3.90	-
21	Байгаль орчныг хамгаалах газар	216.4	233.6	233.6	17.20	-
22	Хотын нийтийн тээвэр	1,200.0	1,200.0	1,200.0	-	-
23	Мал эмнэлгийн үйлчилгээ	26.0	26.0	26.0	-	-
24	Ахмадын хорооны төсөв	75.0	75.0	75.0	-	-
25	Нийтлэг үйлчилгээний алба	555.6	555.6	555.6	-	-
26	Цэцэрлэгжүүлэлт ногоон байгууламжийн газар	375.5	375.5	375.5	-	-
	<b>Нийт</b>	<b>23,389.5</b>	<b>23,601.6</b>	<b>23,601.6</b>	212.10	0

Аймгийн ИТХ төсөвт 2 удаа тодотгол хийж анх батлагдсан төсвийг аймгийн ИТХ-ын 2021 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн 07 дугаар тогтоолоор 212.1 сая төгрөгөөр нэмэгдүүлж 23,601.6 сая төгрөг болгосон.

Төсөвт тодотгол хийж өөрчлөлт оруулахдаа 8 зардлыг 607.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 3 төрлийн зардлыг 394.9 сая төгрөгөөр бууруулсан байна. Үүнд:

- Аймгийн ИТХ-ын төсвийг 52.4 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 1,151.2 сая төгрөг.
- Баян-Өндөр суманд олгох санхүүжилтийг 180.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 2,923.8 сая төгрөг.
- Аймгийн ЗДТГ-ыг төсвийг 140.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 2,637.6 сая төгрөг.
- Хот тохижуулах газрын төсвийг 88.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 4,672.6 сая төгрөг.
- Орон нутгийн өмчийн газрын төсвийг 13.5 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 308.4 сая төгрөг.
- Сургуулийн өмнөх боловсролын тогтмол зардлыг 112.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 1,367.0 сая төгрөг.

- Мэдээлэл шуурхай удирдлагын төвийн төсвийг 3.9 сая төгрөг нэмэгдүүлж, 131.2 сая төгрөг.
- Байгаль орчны газрын төсвийг 17.2 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 233.6 сая төгрөг болгон тус тус өөрчилсөн байна.

Тодотголоор зардал бууруулахдаа Жаргалант суманд олгох санхүүжилтийг 7.7 сая төгрөгөөр бууруулж 1,451.5 сая төгрөг, байгаль орчин нөхөн сэргээх зардлыг 252.4 сая төгрөгөөр бууруулж 1,468.9 сая төгрөг, автозамын сангийн төсвийг 134.8 сая төгрөгөөр бууруулж 1,263.1 сая төгрөг болгон тодотгосон байна.

Харин 2021 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 05/02 дугаар тогтоолоор Жаргалант суманд олгох төсвийг анх батлагдсан 1,459.2 сая төгрөгийн төсвөөс 7.7 сая төгрөгөөр бууруулсныг дахин 4.4 сая төгрөгөөр нэмэгдүүлж 1,455.9 сая төгрөгөөр баталсан байна.

Сургуулийн өмнөх боловсролын тогтмол зардлыг анхны төсвөөс 1,255.0 сая төгрөгөөр баталсныг 112.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж 1,367.0 сая төгрөг болсныг оны эцэст 1.6 сая төгрөгөөр бууруулж 1,365.4 сая төгрөг болгосон байна.

Ерөнхий боловсролын байгууллагын тогтмол зардлыг анхны төсвөөр 1,504.8 сая төгрөг байсныг оны эцэст 2.8 сая төгрөгөөр бууруулж 1,502.0 сая төгрөгөөр баталсан байна.

Аймгийн ИТХ-ын 2020 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн 02/05 дугаар тогтоолоор улсын төсөвт төвлөрүүлэх орлогыг 27,585.6 сая төгрөгөөр баталсан бол АИТХ-ын 2021 оны 09 дүгээр сарын 15-ны 7 дугаар тогтоолоор 2,984.0 сая төгрөгөөр бууруулж, 24,601.6 сая төгрөгөөр баталсан.

**Баян-Өндөр сум:** Баян-өндөр сумын ИТХ-ын 2020 оны 12 сарын 18-ны ээлжит 2-р хуралдааны 07 дугаар тогтоолоор Баян-өндөр сумын 2021 оны төсвийг батлахдаа орлогын эх үүсвэрийг төсвийн санхүүгийн дэмжлэг 2,743.8 сая, ОНХС-ийн шилжүүлэг 730.5 сая төгрөг, урьд оны шилжих үлдэгдэл 228.3 сая төгрөг нийт 3,702.6 сая төгрөгөөр баталсан.

Баян-Өндөр сумын ИТХ-ын урсгал зардлыг 224.7 сая төгрөг, ЗДТГ-ын урсгал зардлыг 2,519.1 сая төгрөг, ОНХС-ийн хөрөнгө оруулалтыг 958.8 сая төгрөгөөр тус тус баталсан.

Баян-Өндөр сумын ИТХ-ын 2021 оны 09 дүгээр сарын 29-ны 04 дүгээр тогтоолоор төсвийн санхүүгийн дэмжлэгийг 2,923.8 сая төгрөг, ОНХС-ийн орлогын шилжүүлгийг 730.5 сая төгрөг, урьд оны шилжих үлдэгдэл 228.3 сая төгрөг, нийт 3,882.6 сая төгрөг болгож 180.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж тодотгосон байна.

**Жаргалант сум:** Жаргалант сумын ИТХ-ын 2020 оны 12 сарын 17-ний өдрийн 5 дугаар тогтоолоор сумын нийт татварын орлогыг 36.9 сая төгрөгөөр, татварын бус орлогыг 40.5 сая төгрөг, нийт урсгал орлого 77.4 сая төгрөгөөр, санхүүгийн дэмжлэг 3,060.6 сая төгрөг, ОНХС-ын орлого 933.0 мянган төгрөг, нийт тусламжийн орлого 3,993.6 сая төгрөг байхаар баталсан байна.

Жаргалант сумын ИТХ-ын урсгал зардлыг 165.9 сая төгрөг, ЗДТГ-ын урсгал зардлыг 1,049.0 сая төгрөг, нийт 1,214.9 сая төгрөгөөр баталсан.

Жаргалант сумын ИТХ-ын 2021 оны 09 дүгээр сарын 22-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор татварын бус орлогыг 3.5 сая төгрөгөөр нэмэгдүүлж 44.0 сая төгрөг, татварын орлогыг 111.3 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 148.2 сая төгрөгөөр тодотгон баталсан.

Жаргалант сумын төсвөөс сумын ИТХ-д 165.9 сая төгрөг, ЗДТГ-т 1,163.8 сая төгрөг, сумын соёлын төвд 107.9 сая төгрөг, нийт 1,437.6 сая төгрөг, сум хөгжүүлэх сангаас олгох санхүүгийн зээлийн хэмжээ 170.6 сая төгрөг, ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэх хөрөнгө оруулалтыг 1,107.6 сая төгрөг байхаар тодотгол хийжээ.

**1.2 Төсөвт 2 удаа тодотгол хийж хөрөнгө оруулалтын зардлыг 5,011.0 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн.**

Аймгийн 2021 оны төсвийн жилд орон нутгийн хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөрийн зардлыг дараах байдлаар баталсан байна.

№	Зардлын төрөл	Аймгийн ИТХ-ын 2020.11.30 02/05	Аймгийн ИТХ-ын 2021.09.15 07	Аймгийн ИТХ-ын 2021.12.28 05/02
		1	2	3
1	<b>Орон нутгийн хөрөнгө оруулалт</b>	<b>31,345.6</b>	<b>36,356.6</b>	<b>36,356.6</b>
2	Үүнээс: Хөрөнгө оруулалт	24,830.6	27,540.3	27,540.3
3	Төсөл хөтөлбөр	6,515.0	8,816.3	8,816.3
4	<b>Аймгийн ОНХС</b>	<b>4,469.2</b>	<b>4,068.0</b>	<b>4,068.0</b>
5	Үүнээс: Хөрөнгө оруулалтын зардал	4,369.2	3,968.0	3,968.0
6	Төсөл, хөтөлбөрийн зардал	100.0	100	100.0

Аймгийн ИТХ-аар хөрөнгө оруулалтын зардлыг анх батлахдаа 24,830.6 сая төгрөгөөр баталсан бол 2021 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн 07 дугаар тогтоолоор 2,709.7 сая төгрөгөөр нэмэгдүүлж 27,540.3 сая төгрөг болгож тодотгосон.

Төсөл хөтөлбөрийн зардлыг 137 төсөл арга хэмжээнд 6,515.0 сая төгрөг зарцуулахаар баталж, тодотголоор 136 төсөл арга хэмжээнд 8,816.3 сая төгрөг зарцуулахаар 2,301.3 сая төгрөгөөр нэмж төсвийг тодотгосон.

Хөрөнгө оруулалтын зардалд батлагдсан 24,830.6 сая төгрөгөөс 111 төсөл арга хэмжээний 11,521.8 сая төгрөг нь шилжих хөрөнгө оруулалт, шинээр хэрэгжих хөрөнгө оруулалт 123 төсөл арга хэмжээний 13,308.8 сая төгрөг зарцуулахаар төлөвлөсөн бол тодотголоор 27,540.3 сая төгрөг болсноос шилжих хөрөнгө оруулалт 90 төсөл арга хэмжээний 7,985.9 сая төгрөг, шинээр эхлэх хөрөнгө оруулалт 126 төсөл арга хэмжээнд 19,554.4 сая төгрөг зарцуулахаар тус тус батлагдсан.

Байгаль орчныг хамгаалах арга хэмжээний зардлаар 53 төсөл арга хэмжээний 1,721.3 сая төгрөг батлагдсан бол тодотголоор 53 төсөл арга хэмжээнд 1,468.9 сая төгрөг зарцуулахаар тодотгол хийсэн.

Авто замын сангийн хөрөнгөөр 18 төсөл арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,397.9 сая төгрөг батлагдсан бол тодотголоор 17 төсөл арга хэмжээг 1,263.1 сая төгрөг болгож, 134.8 сая төгрөгөөр бууруулан баталсан байна.

Хөрөнгө оруулалтын төлөвлөгөө: /сая төгрөг/

№	Хөрөнгө оруулалтын задаргаа	ТАХ-ний	Батлагдсан мөнгөн дүн
1	<b>Хөрөнгө оруулалт</b>	<b>352</b>	<b>36,356.6</b>
2	Үүнээс: Шинээр хийгдэх хөрөнгө оруулалт	126	19,554.4
3	Шилжих үлдэгдлээр	90	7,985.9
4	Төсөл хөтөлбөр	136	8,816.3
5	<b>Байгаль хамгаалах арга хэмжээ</b>	<b>53</b>	<b>1,468.9</b>
6	Үүнээс: Шинээр хийгдэх хөрөнгө оруулалт	11	1,177.0
7	Шилжих хөрөнгө оруулалт	6	291.9
8	Төсөл хөтөлбөр	36	497.5
9	<b>Авто замын сан</b>	<b>17</b>	<b>1,263.1</b>
10	Үүнээс: шинээр хийгдэх хөрөнгө оруулалт	2	370.8
11	Шилжих хөрөнгө оруулалт	14	696.6
12	Төсөл хөтөлбөр	1	195.7

	<b>ОНХС-ийн хөрөнгө оруулалт</b>	<b>28</b>	<b>4,068.0</b>
	Үүнээс: шинээр хийгдэх хөрөнгө оруулалт	18	3,580.2
	Шилжих хөрөнгө оруулалт	9	387.8
	Төсөл хөтөлбөр	1	100.0
<b>6</b>	<b>Нийт төсөл арга хэмжээний дүн</b>	<b>450</b>	<b>43,156.6</b>

Харин ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэх хөрөнгө оруулалтын зардлыг 30 төсөл арга хэмжээнд 4,369.2 сая төгрөг зарцуулахаар баталж, тодотголоор 28 төсөл арга хэмжээг 4,068.0 сая төгрөг болгож, 401.2 сая төгрөгөөр бууруулж тодотгосон.

Аймгийн ИТХ-ын 2021 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн 02/06 дугаар тогтоолоор Эрдэнэт сангийн орлогыг 15,069.9 сая төгрөг, зардлыг 15,069.9 сая төгрөг байхаар баталсан бол аймгийн ИТХ-ын 2021 оны 09 дүгээр сарын 16-ны өдрийн 08 дугаар тогтоолоор Эрдэнэт сангийн төсөв өөрчлөлт оруулж орлогыг 3,126.1 сая төгрөгөөр бууруулж 11,943.8 сая төгрөг, зардлыг мөн адил 3,126.1 сая төгрөгөөр бууруулж 11,943.8 сая төгрөг болгож тодотгосон.

Өмнөх оны буюу 2020 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар аймгийн ИТХ-ын 2014 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 05 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан Эрдэнэт сангийн дүрэмд зааснаар тус сан нь аймаг хөгжүүлэх, иргэдийн эрх ашгийг хамгаалах үйл ажиллагаа явуулж, нийгэмд ашиг тустай хот байгуулалт, тохижилт дэд бүтцийг хөгжүүлэх, аймгийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэх зорилготой гэж заасан.

Тус сангаас “Их шүтээн цогцолбор” ОНӨҮГ-ын үйл ажиллагааны зардал 64.9 сая төгрөг, “Хөх Монгол” цогцолборын үйл ажиллагааны зардал 75.3 сая төгрөг, нийт 140.2 сая төгрөгийн санхүүжилт авахаар төсөв батлагдсан нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 2-т “Өөрт олгогдсон эд хөрөнгийн үндсэн дээр өөрийгөө санхүүжүүлэх зарчмаар ажиллаж бие даан иргэний гүйлгээнд ордог хуулийн этгээдийг аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар гэнэ” гэсэн заалттай нийцэхгүй байсан тул ОНӨҮГ-ын санхүүжилтийг өөрөө өөрийгөө санхүүжих зарчмаар явуулах талаар зохион байгуулалттай арга хэмжээ авах талаар зөвлөмж хүргүүлсний дагуу аймгийн ИТХ-ын 2021 оны 07 дугаар сарын 02-ны өдрийн 19 дүгээр тогтоолоор Хөх Монгол цогцолборыг татан буулгах шийдвэр гаргасан байна.

Мөн Орон нутгийн өмчийн газраас Их шүтээн цогцолбор ОНӨААТҮГ-ыг байгуулагдсанаас хойш үндсэн үйл ажиллагаа болон өөрийн эх үүсвэрээр орлого олж төсөвт төвлөрүүлэх ажил хийгдээгүй, жил бүр орон нутгийн төсвөөс 60,0 орчим сая төгрөгийн санхүүжилт авч байгаа тул татан буулгаж менежментийн хувьчлал болон зориулалтыг өөрчлөхгүй нөхцөлтэйгөөр төсөл сонгон шалгаруулах саналыг засаг даргын зөвлөлийн хуралд хүргүүлсэн боловч дэмжигдээгүй байна.

**БҮЛЭГ 2. Өмнөх оны аудитаар тусгай шилжүүлгийн байгууллагын тогтмол зардлыг өмнөх оны гүйцэтгэлтэй уялдуулан бодитой төлөвлөж байх зөвлөмж хүргүүлсэн боловч хэрэгжилт хангагдаагүй, төрийн сангийн гүйлгээг бөөн дүнгээр хянаснаас шалтгаалж нэг ижил дүнтэй гүйлгээ 2 давхардаж гарсан.**

**2.1 Орон нутгийн татварын орлого 9,939.8 сая төгрөгөөр давж биелсэн бол бусад орлого 194.0 сая төгрөгөөр тасарсан байна.**

Аймгийн татварын орлогын төлөвлөгөөг нэр төрлөөр авч үзвэл 15 нэр төрлийн татварын орлого 114.5 хувь буюу 9,939.8 сая төгрөгөөр давж биелсэн байна.

**ОРХОН АЙМГИЙН 2021 ОНЫ ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**

Татварын орлогыг нэр төрлөөр үзүүлбэл:

/сая.төгрөг/

Орлогын нэр төрөл	2020 оны гүйцэтгэл	2021 он			
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Татварын орлого	<b>40,095.4</b>	<b>39,132.3</b>	<b>42,253.1</b>	<b>(3,120.8)</b>	<b>108.0</b>
Цалин хөлс түүнтэй адилтгах орлого	35,767.9	36,611.2	37,949.8	(1,338.6)	103.7
Үйл ажиллагааны орлого	440.5	271.5	280.0	(8.5)	103.1
Хөрөнгийн орлого /хадгаламжийн хүү/	3,194.4	2,960.0	3,230.8	(270.8)	109.1
Хөрөнгө борлуулсны орлого	1,168.1	1,050.0	2,344.9	(1,294.9)	223.3
Шууд бус орлого	1,508.5	650.4	858.4	(208.0)	132.0
ХХОАТ-ын буцаалт	(1,984.0)	(2,410.8)	(2,410.8)	-	100.0
<b>хөрөнгийн албан татвар</b>	<b>9,511.4</b>	<b>9,456.4</b>	<b>13,038.9</b>	<b>(3,582.5)</b>	<b>138.00</b>
Үл хөдлөх хөрөнгийн татвар	8,459.9	8,449.0	11,902.0	(3,453.0)	140.9
Бууны татвар	37.9	40.8	37.2	3.6	91.2
АТБӨЯХАТатвар	1,013.6	966.6	1,074.8	(108.2)	111.2
малд ногдуулах албан татвар			24.9	(24.9)	
<b>Бусад татвар төлбөр хураамж</b>	<b>1,653.4</b>	<b>1,037.8</b>	<b>3,108.3</b>	<b>(2,070.5)</b>	<b>116</b>
Улсын тэмдэгтийн хураамж	694.8	441.5	386.6	54.9	87.6
ТТАМ-н ОАТ	44.1	24.8	40.9	(16.1)	164.8
Хог хаягдлын хураамж	525.2	571.5	666.3	(94.8)	116.6
Бусад татвар	389.3	-	2,014.5	(2,014.5)	
<u>Газрын төлбөр</u>	19,461.4	18,386.4	19,083.0	(696.6)	103.8
<u>газрын дуудлага худалдаа</u>			400.8	(400.8)	
<u>Байгалийн нөөц ашигласны төлбөр</u>	<b>356.3</b>	<b>311.2</b>	<b>379.9</b>	<b>(68.7)</b>	<b>110.4</b>
Ойн нөөц ашигласны	16.8	-	27.3	(27.3)	
Ус рашааны нөөц ашигласны	339.5	311.2	352.6	(41.4)	113.3
Нийт дүн	<b>71,077.9</b>	<b>68,324.1</b>	<b>78,263.9</b>	<b>(9,939.8)</b>	<b>114.5</b>

Орон нутгийн төсөвт төвлөрөх 2021 оны татварын орлогыг 68,324.1 сая төгрөгөөр төлөвлөж гүйцэтгэлээр 78,263.9 сая төгрөг төвлөрч 9,939.8 сая төгрөг буюу 14.5 хувиар давж биелсэн байна. Давсан орлогын шалтгааныг тогтооход дараах байдалтай байна. Тухайлбал:

- **Цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын албан татварын** орлогыг 36,611.2 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 37,949.8 сая төгрөг төвлөрч 1,338.6 сая төгрөг буюу 3.7 хувиар давсан нь Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын захирлын 2021 оны 05 дугаар сарын 31-ны өдрийн А/257 дугаар тушаалаар нийт ажилчдын цалинг 10%-аар нэмэгдүүлсэнтэй холбоотой байна.
- **Хөрөнгийн орлогын** татварыг 2,960.0 сая төгрөгөөр төлөвлөн, гүйцэтгэлээр 3,230.8 сая төгрөг төвлөрч, 270.8 сая төгрөг буюу 9.1 хувиар давсан нь хадгаламжийн эзэмшигчийн тоо нэмэгдэж түүний хүүгийн орлого орон нутагт төвлөрдгөөс шалтгаалсан байна.
- **Хөрөнгө борлуулсны орлого** 1,050.0 сая төгрөг төлөвлөж гүйцэтгэлээр 2,344.9 сая төгрөг төвлөрч, 1,294.9 сая төгрөг буюу 123 хувиар давж биелсэн.
- **Үл хөдлөх хөрөнгийн татварыг** 8,449.0 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 11,902.0 сая төгрөг төвлөрч, 3,453.0 сая төгрөгөөр буюу 40.8 хувиар давсан.

- **Хог хаягдлын хураамжийг** 571.5 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 666.3 сая төгрөг төвлөрч, 94.8 сая төгрөг буюу төлөвлөгөөний биелэлт 16.6 хувиар давж биелсэн нь Засгийн газрын 2020 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 211 дүгээр тогтоолоор айл өрхийн болон дор дурдсанаас бусад аж ахуйн нэгж, байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, дулааны уур хэрэглэсний төлбөр, цэвэр, бохир усны үйлчилгээний төлбөр болон энгийн хог хаягдлын үйлчилгээний хураамжийг 2020 оны 12 дугаар сарын 1-ний өдрөөс тооцож 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл хугацаанд төрөөс хариуцан төлөх болсонтой холбоотойгоор 2020 оны үлдэгдэл санхүүжилт 2021 онд шилжиж орсон тул орлогын төлөвлөгөө давж биелсэн байна.
- **Газрын төлбөрийн** орлогыг 2021 онд 18,386.4 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 19,083.0 сая төгрөг орж, төлөвлөгөөнөөс 696.6 сая төгрөгөөр буюу 3.8 хувиар давж биелсэн нь “Уулын баяжуулах Эрдэнэт Үйлдвэр” ТӨҮГ-т жил бүр орон нутгаас усны алдагдлын зөрүүнд 2,040.0 сая төгрөгийг газрын төлбөрт суутган тооцдог байсныг энэ жил суутган тооцоогүй газрын төлбөрт нийлүүлж шилжүүлсэнтэй холбоотой байна.

Татварын бус болон бусад орлогыг нэр төрлөөр харуулбал: /сая.төгрөг/

Орлогын нэр төрөл	2020 оны гүйцэтгэл	2021 он			
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Хүүгийн орлого	3.7	-	-	-	
Торгуулийн орлого	1,475.7	830.0	1,755.2	(925.2)	211.47
Бусад орлого	304.7		171.5	(171.5)	
Үндсэн үйл ажиллагааны орлогоос	16,689.3	3,020.5	1,936.8	1,083.7	64.1
туслах үйл ажиллагааны орлогоос	52.5	26.6	16.4	10.2	61.7
<b>Төсөвт байгууллагын өөрийн орлого</b>	<b>18,525.9</b>	<b>3,877.1</b>	<b>3,879.9</b>	<b>(2.8)</b>	
Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	43,234.8	42,180.9	41,984.0	196.9	99.5
ОНХС-ийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого	4,006.5	5,353.7	5,353.7	-	100.0
<b>Тусламж, санхүүжилтийн орлого</b>	<b>47,241.3</b>	<b>47,534.6</b>	<b>47,337.7</b>	<b>196.9</b>	<b>199.5</b>
<u>Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих</u>		<b>29.9</b>	<b>30.0</b>	<b>(0.1)</b>	<b>100.3</b>
<b>Нийт дүн</b>	<b>65,767.20</b>	<b>51,441.60</b>	<b>51,247.60</b>	<b>194.00</b>	<b>99.62</b>

- Татварын бус орлогоос 2021 онд хүү, торгуулийн орлогыг 830.0 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 1,755.2 сая төгрөг төвлөрч 925.2 сая төгрөгөөр давж биелсэн.
- Үндсэн үйл ажиллагааны орлогыг 3,020.5 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 1,936.8 сая төгрөг төвлөрч 1,083.7 сая төгрөгөөр тасарсан нь Эрдэнэт санд орох Эрдэнэт үйлдвэртэй хамтын ажиллагааны санхүүжилт орж ирээгүйтэй холбоотой байна.
- Туслах үйл ажиллагааны орлогын төлөвлөгөө 26.6 сая төгрөгөөс гүйцэтгэлээр 16.4 сая төгрөг төвлөрч 10.2 сая төгрөг тасарсан нь ковид цар тахалтай холбоотой сургуулиудын цайны газрын түрээсийн орлого бүрэн төвлөрөөгүй байна.

**2.2. Тусгай шилжүүлгийн байгууллагын тогтмол зардлыг өмнөх оны гүйцэтгэлтэй уялдуулан бодитой төлөвлөж байх зөвлөмж хүргүүлсэн боловч хэрэгжилт**

хангагдаагүй, төрийн сангийн гүйлгээг бөөн дүнгээр хянаснаас шалтгаалж нэг ижил дүнтэй гүйлгээ 2 давхардаж гарсан.

Орон нутгийн төсвийн гүйцэтгэлийг өмнөх оны төсвийн гүйцэтгэлтэй харьцуулахад 3,384.9 сая төгрөг буюу 2.6%-аар буурсан байна.

Тус онд орон нутгийн төсвөөс 145,678.67 сая төгрөгийн орлогын эх үүсвэрээс бараа үйлчилгээний зардалд 81,481.4 сая төгрөг буюу 55.9%, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд 23,524.5 сая төгрөг буюу 16.1%, урсгал шилжүүлэгт 26,609.2 сая төгрөг буюу 18.3 %, хөрөнгийн зардалд 35,809.3 сая төгрөг буюу 24.6%-ийг тус тус зарцуулахаар төлөвлөсөн байна.

2021 оны төсвийн зарлагын гүйцэтгэлийг хүснэгтээр харуулбал: /сая төгрөг/

Код	Үзүүлэлт	2020 оны гүйцэтгэл	2021 оны төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэл	Гүйцэтгэл зөрүү	Хувь
II	<b>Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн</b>	<b>132,464.62</b>	<b>145,678.67</b>	<b>129,079.63</b>	<b>16,599.04</b>	<b>88.61</b>
21	<b>Урсгал зардал</b>	<b>107,505.47</b>	<b>109,290.54</b>	<b>98,563.34</b>	<b>10,727.21</b>	<b>90.18</b>
210	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>75,565.83</b>	<b>81,481.36</b>	<b>70,977.84</b>	<b>10,503.52</b>	<b>87.11</b>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	40,146.41	41,074.23	40,683.04	391.19	99.05
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	5,152.86	5,503.46	5,399.47	103.99	98.11
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	2,322.44	3,776.69	2,593.81	1,182.88	68.68
2104	Хангамж, бараа материалын зардал	1,978.22	1,844.28	1,814.11	30.17	98.36
2105	Нормативт зардал	2,530.63	914.88	896.69	18.19	98.01
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	796.56	753.90	748.05	5.85	99.22
2107	Томилолт, зочны зардал	114.47	174.32	143.07	31.24	82.08
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	18,691.93	23,524.45	14,879.92	8,644.54	63.25
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,832.31	3,915.16	3,819.69	95.47	97.56
2122	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	1,127.89	1,200.00	1,030.86	169.14	85.90
213	Урсгал шилжүүлэг	30,811.75	26,609.18	26,554.64	54.54	99.80
22	Хөрөнгийн зардал	24,581.00	35,809.34	30,114.71	5,694.63	84.10
23	Эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл	378.15	578.79	401.59	177.20	69.38
III	<b>Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр</b>	<b>139,495.0</b>	<b>145,678.67</b>	<b>125,622.26</b>	<b>20,056.41</b>	<b>86.23</b>
31	Улсын төсвөөс санхүүжих	46,514.08	47,534.65	47,337.71	196.94	99.59
32	Орон нутгийн төсвөөс санхүүжих	63,438.18	69,273.80	76,331.34	-7,057.55	110.19
33	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	30.11	29.91	30.02	-0.12	100.39
35	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	29,512.64	28,840.32	1,953.21	26,887.11	6.77

Тайлант оны төсвийн хэмнэлт дараах шалтгаануудаас үүдэлтэй байна. Үүнд:

- Цалин, хөлс, нэмэгдэл урамшуулал, НДШ-ийн зардал 495.2 сая төгрөгийн хэмнэлттэй зарцуулсан нь Хүүхэлдэйн театр 57.5 сая, аймгийн ЗДТГ 74.6 сая, аймгийн ИТХ 29.5 сая, Нийтлэг үйлчилгээний алба 14.6 сая, Орон нутгийн өмчийн газар 13.2 сая, Жаргалант сумын ЗДТГ 24.4 сая, Хүүхэд гэр бүл хөгжлийн хэлтэс 17.7 сая, Аялгуу соёлын төв 48.3 сая гэх мэт нийт 25 байгууллагаас хэмнэгдсэн нь орон тоо дутуу ажилласнаас шалтгаалсан байна.
- Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 1,182.9 сая төгрөгөөр хэмнэгдсэн нь тус онд сургууль цэцэрлэгүүдийн ажиллаагүй үеийн ашиглалтын зардлууд хэмнэгдэж үлдсэн байна.
- Томилолтын зардал 31.24 сая төгрөгөөр хэмнэгдсэн нь Ковид цар тахалтай холбоотойгоор тус зардал хэмнэлт үүссэн.
- Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардал 8,644.5 сая төгрөгөөр хэмнэгдсэн нь Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-тай хамтын ажиллагааны хүрээнд хийгдэж буй 1А хорооллын дэд бүтэц барих ажлын санхүүжилт тус үйлдвэрээс орж ирээгүй тул гүйцэтгэл 7,458.8 сая төгрөг олгогдоогүй нь гол нөлөөлсөн.
- Хувийн хэвшилд олгох татаас санхүүжилт 169.1 сая төгрөгөөр хэмнэгдсэн нь цар тахалтай холбоотойгоор 2021 оны эхний хагас жилд хотын нийтийн тээвэрт үйлчилдэг тээврийн хэрэгслийн тоо, чиглэлийг бууруулсантай холбоотой хэмнэлт үүссэн байна.
- Бусад урсгал шилжүүлэг 54.5 сая төгрөгөөр хэмнэгдсэний 19.6 сая төгрөг нь сургуулийн үйл ажиллагаа бүрэн яваагүйтэй холбоотой үдийн цайны зардал хэмнэлт үүсгэсэн, нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшууллын зардал 23.4 сая төгрөг нь Санхүү хяналт аудитын албаны тэтгэвэрт гаргахад олгох тэтгэмж 13.9 сая төгрөг, Хүүхэлдэйн театрын 6.3 сая, Эгшиглэн соёлын төвийн 2.7 сая төгрөгийн зарцуулагдаагүй үлдэгдэл хэмнэлт үүсэх гол шалтгаан болсон.
- Хөрөнгийн зардал 5,694.6 сая төгрөгөөр хэмнэгдсэн нь орон нутгийн хөрөнгө оруулалт, орон нутгийн хөгжлийн сангийн гүйцэтгэл нь Ковид-19 цар тахалтай холбоотойгоор ажлын гүйцэтгэл гараагүй, худалдан авах ажиллагаа хойшлогдон, зарим ажлууд он дамжиж, дараа онд шилжиж үлдсэнтэй холбоотой байна.

**Ковид 19 цар тахал:** Тайлант онд Ковид 19 цар тахалтай холбоотой тусгай шилжүүлгийн 48 байгууллага 3,439.3 мянган төгрөг, орон нутгийн төсвийн шууд захирагч 29 байгууллага 3,240.0 мянган төгрөг, 8 ӨЭМТ-д 2,005,522.2 мянган төгрөгийн бараа материал 236,116.3 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө нийт 92 байгууллага 2,012,201.5 мянган төгрөгийн бараа материал, 236,116.3 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө хандив тусламжаар бэлтгэсэн байна.

№	Байгууллагын төрөл	Байгууллагын тоо	Бараа материал	Үндсэн хөрөнгө
1	Сургууль	17	2,632.7	-
2	Цэцэрлэг	29	806.6	-
3	ХГБХГ, ГХБХБГ	2	-	-
4	Төсвийн шүүд захирагч	29	3,240.0	-
5	ОНӨААН	7	-	-
6	ӨЭМТ	8	2,005,522.18	236,116.3

**ОРХОН АЙМГИЙН 2021 ОНЫ ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**

<b>Нийт дүн</b>	<b>92</b>	<b>2,012,201.5</b>	<b>236,116.3</b>
-----------------	-----------	--------------------	------------------

Орон нутгийн 92 байгууллага нь цар тахалтай холбоотойгоор 4,639.8 сая төгрөгийг 2021 онд зарцуулсан нь өмнөх оноос 1,171.9 сая төгрөгөөр буурсан байна.

Цар тахалд зарцуулсан зардлаас цалин, урамшуулалд 803,503.7 мянга, ажил олгогчоос төлөх шимтгэлд 92,419.3 мянган төгрөг зарцуулсан. Үүнд: 1 цэцэрлэгийн байгууллага 1,776.8 мянга, ажил олгогчоос төлөх шимтгэл 183.0 мянга, 2 төсвийн шууд захирагчийн цалинд 75,228.8 мянга, ажил олгогчийн шимтгэлд 6,912.5 мянган төгрөг зарцуулсан бол өрхийн мэндийн төвийн 8 байгууллага цалин урамшуулалд 726,498.1 мянган төгрөг, ажил олгогчийн шимтгэлд 85,323.8 мянган төгрөгийг зарцуулжээ.

Ковид цар тахалтай холбоотой зардал:

/мянган.төгрөг/

	<b>Зарлагын эдийн засгийн ангилал</b>	<b>2020 он</b>	<b>2021 он</b>
1	<b>Цалин хөлс, нэмэгдэл урамшуулал</b>	773,503.59	803,503.69
2	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	23,716.94	92,419.27
	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>1,087.00</b>	<b>-</b>
3	Гэрэл, цахилгаан	127.00	-
4	Түлш, халаалт	960.00	
	<b>Хангамж бараа материалын зардал</b>	<b>752,168.43</b>	<b>270,490.35</b>
7	Бичиг хэрэг	12,227.80	2,568.30
8	Тээвэр шатахуун	164,183.80	31,101.40
9	Шуудан холбоо, интернетийн төлбөр	8,210.50	6,206.00
10	Ном хэвлэл	60.50	157.60
11	Хог хаягдал зайлуулах, хортой мэрэгчдийн устгал ариутгал,	391,463.91	131,167.55
12	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	176,021.92	99,289.50
	<b>Нормативт зардал</b>	<b>3,289,955.09</b>	<b>2,330,736.58</b>
13	Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,820,174.11	2,289,432.33
14	Хоол хүнс	417,193.78	28,178.25
15	Нормын хувцас, зөөлөн эдлэл	52,587.20	13,126.00
	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>671,587.06</b>	<b>577,260.94</b>
16	Багаж, техник хэрэгсэл	29,944.70	18,185.20
18	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	624,541.56	556,953.44
19	Урсгал засвар	17,100.80	2,122.30
	<b>Томилот зочны зардал</b>	<b>832.00</b>	<b>522.00</b>
21	Дотоод албан томилот	832.00	114.00
22	Зочин төлөөлөгч хүлээн авах		408.00
23	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>29,638.00</b>	<b>35,834.70</b>
24	<b>Бараа ажил үйлчилгээний төлбөр</b>	<b>81,000.00</b>	<b>17,933.85</b>
	<b>Урсгал шилжүүлэг</b>	<b>77,722.20</b>	<b>365,127.78</b>
32	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	34,650.00	
33	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал	43,072.20	328,427.78
34	Төрөөс иргэдэд олгох бусад тэтгэмж, дэмжлэг		36,700.00
	<b>Хөрөнгийн зардал</b>	<b>110,590.00</b>	<b>145,989.98</b>
36	Их засвар		3,844.60
37	Тоног төхөөрөмж	110,590.00	142,145.38
	<b>УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>5,811,800.31</b>	<b>4,639,819.13</b>

**ЭМГ-т ковидтой холбоотой дараах санхүүжилт орсон. Үүнд:**

- Эрүүл мэндийн яамнаас Коронавируст халдвар дотоодод тархсантай холбоотойгоор тусгаарлах байр, шуурхай хариу арга хэмжээний багууд болон хяналтын цэгүүдэд ажилласан албан хаагчдын илүү цагийн хөлс 115.2 сая төгрөг
- Коронавируст халдвар дотоодод тархсантай холбоотойгоор Эрүүл мэндийн салбарт ажиллаж байгаа нийт албан хаагчдад нэг удаагийн санхүүгийн дэмжлэг үзүүлэх санхүүжилт 969.4 сая төгрөг
- Улаанбаатар хотод дайчлагдан ажилласан албан хаагчдын илүү цагийн хөлс 2.8 сая төгрөг нийт 1,087.4 сая төгрөгийн санхүүжилт орж ирснийг зарцуулжээ.

**Үнэ төлбөргүй ирсэн орлого:**

1. Эрүүл мэндийн яамнаас 1,045.4 сая төгрөгийн нэг удаагийн хамгаалах хувцас хэрэглэл, эм тариа, эм хэрэгсэл, түргэвчилсэн оношлуур гэх мэт.
2. ХӨСҮТ-өөс 6,435.6 сая төгрөгийн коронавируст халдварын вакцин, вакцины дагалдах хэрэгсэл болон зориулалтын хөргүүр, амьсгалын замын эм тариа, товлолын вакцин нийт 7,481.0 сая төгрөгийн бараа материал болон хөрөнгийн орлогыг Эрүүл мэндийн төв болон БОЭТ-д олгосон байна.

**Онцгой комисс:**

Аймгийн төсөл хөтөлбөрийн зардалд онцгой байдлын комиссын зардал 2,521.96 сая төгрөг батлагдаж гүйцэтгэлээр 2,446.2 сая төгрөгийн санхүүжилт авсан байна. Мөн Засаг даргын нөөц сангаас 74.6 сая, болзошгүй аваарын зардал 513.7 сая, эмч дэд хөтөлбөрийн зардлаас 15.0 сая төгрөг нийт 3,049.5 сая төгрөгийн санхүүжилт авсан.

Шинжилгээний төлбөр 529.7 сая, 6 аж ахуйн нэгж байгууллагаас 8.5 сая төгрөгийн мөнгөн хандив, 13 иргэн аж ахуйн нэгж байгууллагаас 10.4 сая төгрөгийн амны хаалт, хамгаалалтын хувцас, нойтон сальфетка, хоол зэргийг хандиваар авсан байна.

Аймгийн онцгой комисст төвлөрсөн орлогоос 3,496.8 сая төгрөгөөр дараах зардлуудыг санхүүжүүлсэн байна. Үүнд:

- Эрүүл мэндийн байгууллагуудын албан хаагчийн урамшуулал, ажилчдын амин дэмийн зардалд 160.3 сая төгрөг.
- Холбоо харилцаа, бичиг хэрэг, сэрэмжлүүлэг, мэдээлэл сурталчилгааны зардалд 81.2 сая төгрөг.
- Хоол унаа тээвэр шатахууны зардалд 485.7 сая төгрөг.
- Хамгаалах хувцас хэрэглэлд 943.3 сая төгрөг.
- Тоног төхөөрөмж, лабораторийн туслах материалд 879.1 сая төгрөг.
- Тусгаарлах байрны /иргэд, эмч эмнэлгийн ажилчдын тусгаарлах зардалд 343.8 сая төгрөг.
- Засвар тохижилтын ажилд 152.8 сая төгрөг.
- Бусад зардалд 450.6 сая төгрөг.

2021 оны 04 дүгээр сар, 12 дугаар сард хийгдсэн зарлагын гүйлгээ программын ачааллаас шалтгаалж гацалт үүссэн гэх боловч зарлагын гүйлгээг хянаж баталгаажуулахдаа бөөн дүнгээр хянаснаас хамаарч 1 ижил дүн, утгатай гүйлгээ 2 дахин хийгдэж зарим байгууллага авлагаар бүртгэж, зарим нь тайлант оны зардлаар тайлагнасан байна. Тухайлбал:

- Аймгийн Засаг даргын 2021 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн А/704 дүгээр захирамжаар “Чанарын менежментийн тогтолцоо” ISO 9001:2015 стандартын дотоод аудиторын сургалтад хамрагдах 6 албан хаагчийн сургалтын төлбөрт 2,700.0

мянган төгрөгийг Ворлд стандарт консалтинг ХХК-д шилжүүлэхдээ 2021 оны 12 дугаар сарын 21-ны өдөр, 2021 оны 12 дугаар 24-ны өдөр 2 давхар шилжүүлж, илүү шилжүүлсэн төлбөрийг буцааж төсөвт төвлөрүүлээгүй, санхүүгийн тайланд авлагаар бүртгээгүй, тайлант оны зардлаар тайлагнаж төсвийг үр ашиггүй зарцуулсан.

- Аймгийн Засаг даргын 2021 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн А/234 дүгээр захирамжаар “хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн эмхэтгэл” номыг хэвлүүлэхэд шаардагдах зардал 9,900.0 мянган төгрөг, мөн өдрийн А/235 дугаар захирамжаар захиргааны байгууллагуудын 2020 оны үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийх зардал 2,910.0 мянган төгрөгийг төсөл хөтөлбөрийн зардлаас 2021 оны 04 дүгээр сарын 28-ны өдөр Гэсэрийн хошуу ХХК-д шилжүүлсэн байтал 2021 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр дахин давхардуулан 12,810.0 мянган төгрөгийг шилжүүлж оны эцэст авлагаар бүртгэсэн боловч одоог хүртэл барагдаагүй байна.

Дээрх зөрчлүүдэд санхүүгийн тайлангийн аудитаар төлбөрийн акт тогтоосон боловч орон нутгийн төсвөөс төрийн сангаар зарлагын гүйлгээ хийгддэг 92 байгууллагын хэдэн байгууллагад нь давхардсан гүйлгээ хийгдэж, хэдийг нь буцаан төсөвт барагдуулсан нь тодорхойгүй байдал үүссэн байна.

Иймд санхүү төрийн сангийн дотоод хяналт хариуцсан мэргэжилтэн гүйлгээ бүрийг бөөн дүнгээр хянахгүй, нэг бүрчлэн хянаж баталгаажуулж байх шаардлагатай байна.

#### **СӨБ, ЕБС-ын тогтмол зардал:**

Аймгийн ИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 05/02 дугаар тогтоолоор сургуулийн өмнөх боловсролын тогтмол зардалд 1,365,430.6 мянга, ерөнхий боловсролын сургуульд 1,501,985.6 мянга нийт 2,867,416.2 мянган төгрөг баталсан байна. /мян.төгрөг/

№	Зардлын төрөл	СӨБ	ЕБС	Нийт дүн
1	Гэрэл цахилгаан	50,417.2	40,900.0	91,317.2
2	Түлш халаалт	37,881.8	156,834.8	194,716.6
3	Цэвэр бохир ус	42,955.5	109,847.6	152,803.1
	<b>Нийт дүн</b>	<b>131,254.5</b>	<b>307,582.4</b>	<b>438,836.9</b>

Харин дээрх тогтоолоор хувийн сургууль цэцэрлэгийн хувьсах зардлын санхүүжилтийн төсөвт тогтмол зардал 438,836.9 мянган төгрөгийг суулгаж баталсан бөгөөд 2021 онд ашиглалтад орох сургууль, цэцэрлэгийн тогтмол зардлыг батлах гэж оруулсан гэх боловч тайлант онд Уран эгшиг сургууль, 28-р цэцэрлэг ашиглалтад орох төлөвлөгөөтэй байсан байна.

Сургууль цэцэрлэгийн тогтмол зардлыг хувийн сургууль цэцэрлэгийн төсөвт хий суулгаж хэт өндөр дүнгээр батлуулсан байна.

Өмнөх оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн аудитаар тусгай шилжүүлгийн байгууллагын урсгал засвар, тогтмол зардалд 2,802.2 сая төгрөг төлөвлөж, гүйцэтгэлээр 1,872.8 сая төгрөг зарцуулж 929.5 сая төгрөг хэмнэсэн тул тусгай зориулалтын шилжүүлгийн тогтмол зардлыг батлахдаа төсвийн саналыг харгалзан өмнөх оны гүйцэтгэлтэй харьцуулж бодитой төлөвлөж байх тухай зөвлөмж хүргүүлсэн боловч хэрэгжилт хангалтгүй, тайлант онд тогтмол болон урсгал зардалд нийт 3,258.9 сая төгрөг төлөвлөж 2,817.2 сая төгрөг зарцуулж 441.7 сая төгрөг хэмнэсэн байна.

№	Зардлын төрөл	2020 оны төлөвлөгөө гүйцэтгэл			2021 оны төлөвлөгөө гүйцэтгэл		
		төлөв	гүйцэт	Зөрүү	төлөв	гүйцэт	Зөрүү
1	СӨБ тогтмол зардал	1,224.8	804.9	419.8	1,410.5	1,279.2	131.3
2	СӨБ-ын урсгал засвар	57.3	50.2	7.1	72.0	69.6	2.4
3	ЕБС-ын тогтмол зардал	1,256.5	989.2	267.3	1,678.0	1,370.5	307.5
4	ЕБС-ын урсгал завсар	263.6	28.3	235.3	98.4	97.9	0.5
5	<b>Нийт зардал</b>	<b>2,802.2</b>	<b>1,872.8</b>	<b>929.5</b>	<b>3,258.9</b>	<b>2,817.2</b>	<b>441.7</b>

**БҮЛЭГ 3. Ковид цар тахлаас шалтгаалан нэмэлт санхүүжилтийн дансны орлого болон хөрөнгө оруулалтын зардлууд өмнөх оноос буурсан үзүүлэлттэй байна.**

**3.1 Аймгийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний биелэлт 97.4 хувийн биелэлттэй байна.**

Орхон аймгийн Орон нутгийн өмчийн газар нь 2021 оны худалдан авах ажиллагааны ерөнхий төлөвлөгөөнд 34.5 тэрбум төгрөгийн 302 төсөл арга хэмжээг төлөвлөсөн. Үүнд:

- Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 27.9 тэрбум төгрөгийн 162 төсөл арга хэмжээ
- Улсын төсвийн хөрөнгөөр эрх шилжиж ирсэн 3.2 тэрбум төгрөгийн 2 төсөл арга хэмжээ
- Баян-Өндөр сумын ОНХС-ийн хөрөнгөөр 730.6 сая төгрөгийн 40 төсөл арга хэмжээ
- Жаргалант сумын ОНХС-ийн хөрөнгөөр 950.6 сая төгрөгийн 40 төсөл арга хэмжээ
- Хот тохижуулах газрын 838.3 сая төгрөгийн 6 төсөл арга хэмжээ.
- Эрдэнэт Ус ДТС ОНӨХК-ийн 886.8 сая төгрөгийн 51 төсөл арга хэмжээ
- Цэцэрлэгжүүлэлт ногоон байгууламжийн газрын 20.3 сая төгрөгийн 1 төсөл арга хэмжээ.

**Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт:** Орон нутгийн өмчийн газрын 2021 оны ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсан 302 төсөл арга хэмжээний худалдан авалтаас 28,915.2 сая төгрөгийн 78 төсөл арга хэмжээ НТШ, 3,362.1 сая төгрөгийн 100 төсөл арга хэмжээ харьцуулалтын арга, 865.3 сая төгрөгийн 109 төсөл арга хэмжээ шууд худалдан авалтаар, 1,199.2 сая төгрөгийн 15 төсөл арга хэмжээ зөвлөх үйлчилгээний худалдан авах ажиллагааг зохион байгуулсан. Үүнээс:

- Шалгарч гэрээ байгуулсан-294 төсөл арга хэмжээ
- Амжилтгүй болсон-4 төсөл арга хэмжээ
- Зураг төсөв ирээгүй-2 төсөл арга хэмжээ
- ТБОНӨХБАҮХАТХ-ийн 34.2 дэхь хэсэг, 34.1.2 дахь заалтыг үндэслэн гэрээ байгуулсан 2 төсөл арга хэмжээ тус тус байна.

Нийт 302 худалдан авалтын төлөвлөгөөнөөс шалгарч гэрээ байгуулсан 97.3 хувь 294 төсөл арга хэмжээ, тендер зарлаад амжилтгүй болсон 1.3 хувь буюу 4 төсөл арга хэмжээ, зураг төсөв хүлээгдэж буй 0.7 хувь буюу 2 төсөл арга хэмжээ байна.

**Эрх шилжиж ирсэн ажлуудын худалдан авах ажиллагааны биелэлт:** Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэхээр 2021 онд 3.2 тэрбум төгрөгийн 2 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулах эрх шилжиж ирсний дагуу худалдан авах ажиллагааг хууль журмын дагуу зохион байгуулсан. Үүнд:

- ❖ Барилга хот байгуулалтын яам 1.8 тэрбум төгрөгийн 1 төсөл арга хэмжээ
- ❖ Харилцаа холбоо, мэдээлэл технологийн газрын 1.4 тэрбум төгрөгийн 1 төсөл арга хэмжээ

Эрх шилжих ирсэн дээрх 2 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг НТШ-ын аргаар зохион байгуулж 3 аж ахуйн нэгж 3.2 тэрбум төгрөгийн гэрээ байгуулсан байна.

Худалдан авах ажиллагааны тайлан мэдээгээр орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагаа биелснээр харагдаж байгаа боловч санхүүжилтийн зарлагын мэдээгээр хэмнэлттэй байна. Энэ нь худалдан авах ажиллагаа зохион байгуулагдаж гүйцэтгэгч шалгарсан ч цар тахалтай холбоотойгоор төсөл арга хэмжээ бүрэн дуусаж санхүүжилт гараагүйтэй холбоотой байна.

Монгол улсын 2021 оны төсвийн тухай хуулиар Орхон аймгийн ОНХС-д олгох орлогын шилжүүлгийн хэмжээг 5,353.7 сая төгрөгөөр баталснаас аймагт 4,068.0 сая төгрөг, Жаргалант суманд 933.0 сая төгрөг, Баян-өндөр суманд 730.5 сая төгрөг хуваарилахаар аймгийн ИТХ-ын 05/02 дугаар тогтоолд тусгагджээ.

**Аймгийн ОНХС:** Аймгийн хэмжээнд ОНХС-ын эх үүсвэрийг 4,068.0 сая төгрөг, өмнөх оны шилжих үлдэгдэл 679.0 сая төгрөг нийт 4,747.0 сая төгрөгөөр баталсан байна.

Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр 4,068.0 сая төгрөгийг 18 төсөл арга хэмжээг шинэ хөрөнгө оруулалтын ажилд, өмнөх оны 679.0 сая төгрөгийн шилжих үлдэгдлийг 10 төсөл арга хэмжээнд зарцуулахаас 3,814.8 төгрөгийг зарцуулж оны эцэст 279.2 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

**Баян-Өндөр сумын ОНХС:** Тайлант онд 730.5 сая төгрөгийн ОНХС-ийн орлого, шилжих үлдэгдлээс 203.3 сая төгрөг, тендерийн хэмнэлт 25.0 сая төгрөг, нийт 958.8 сая төгрөгийг 4 төсөл арга хэмжээг гүйцэтгэхээр, сумын ИТХ-аар баталсан.

Худалдан авах ажиллагааны 85.0 сая төгрөгийн 1 төсөл арга хэмжээг нээлттэй сонгон шалгаруулалтаар, 498.9 сая төгрөгийн 24 төсөл арга хэмжээг харьцуулалтын аргаар, 32.5 сая төгрөгийн 2 төсөл арга хэмжээг олон нийтийн оролцооны аргаар, 114.2 сая төгрөгийн 13 төсөл арга хэмжээг шууд худалдан авалтын аргаар нийт 40 төсөл арга хэмжээний 730.6 сая төгрөгийн худалдан авах ажиллагааг зохион байгуулсан байна.

Тайлант онд шинээр эхэлсэн 43 төсөл арга хэмжээнд 666.5 сая төгрөг, өмнөх онуудад хэрэгжиж эхлээд дуусаагүй он дамнасан 10 төсөл арга хэмжээнд 47.6 сая төгрөг, хэрэгжиж дууссан ажлуудаас өмнө онд авч үлдсэн баталгааны 5%-ийн санхүүжилт 18 төсөл арга хэмжээнд 21.2 сая төгрөг, захиалагчийн хяналт, зохиогчийн хяналт, зураг төслийн зардалд 24.2 сая төгрөг, нийт 759.5 сая төгрөгийн санхүүжилт тус тус олгосон.

Тайлант онд шинээр эхэлсэн 43 төсөл арга хэмжээнээс 42 төсөл арга хэмжээ бүрэн хэрэгжиж дууссан бол 1 төсөл хөтөлбөрийн нэршил өөрчлөгдөж дараа онд хэрэгжихээр болсон байна.

**Жаргалант сумын ОНХС:** Тайлант онд 933.0 сая төгрөгийн ОНХС-ийн орлого, өмнөх оны үлдэгдэл 174.5 сая төгрөг, нийт 1,107.5 сая төгрөгөөс, хөрөнгө оруулалтын зардалд 704.1 сая төгрөг, төсөл хөтөлбөрийн зардалд 295.3 сая төгрөг, тоног төхөөрөмж худалдан авах зардалд 38.8 сая төгрөг, зөвлөх үйлчилгээнд 69.3 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөсөн байна.

Тайлант оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд шинээр 843.2 сая төгрөгийн 39 төсөл арга хэмжээг зохион байгуулахаар төлөвлөснөөс 298.9 сая төгрөгийн 1 төсөл арга

хэмжээг НТШ, 244.4 сая төгрөгийн 6 төсөл арга хэмжээг харьцуулалтын аргаар, 299.9 сая төгрөгийн 32 төсөл арга хэмжээг шууд худалдан авалтыг аргаар зохион байгуулахаар төлөвлөсөн.

Жаргалант сум ОНХС-аас 911.2 сая төгрөгийг зарцуулж, оны эцэст 187.3 сая төгрөгийн үлдэгдэлтэй, төлөвлөсөн төсөл арга хэмжээнээс 26 төсөл арга хэмжээ бүрэн дууссан байна.

### 3.2 2020 онтой харьцуулахад нэмэлт санхүүжилтийн дансны орлого 485.6 сая, зардал 490.6 сая төгрөгөөр тус тус буурсан байна.

Нэмэлт санхүүжилтийн нэгтгэсэн тайлангаар тус дансанд 2021 онд 5,940.2 сая төгрөгийн орлогын эх үүсвэр бүрдүүлж, 5,929.9 сая төгрөгийг зарцуулсан ба зарцуулаагүй үлдэгдэл 230.2 сая төгрөгийг орон нутгийн төсөвт, 10.3 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна. Өмнөх онтой харьцуулахад зардал 221.7 сая төгрөгөөр буурсан байна.

Нэмэлт санхүүжилтийн орлогыг графикаар харуулбал: (сая.төгрөг)



**Хандив тусламжийн орлого:** Тус орлогоор 260.5 сая төгрөг бүртгэгдсэн нь боловсролын салбарын 4-р сургууль, 14-р сургууль, 8-р цэцэрлэгийн эцэг эхийн хандив, 5-р сургууль, 15-р сургууль, аймгийн ИТХ, Байгаль орчин аялал жуулчлалын газарт гаднын төслөөс хийгдсэн санхүүжилтийн орлогоос бүрдсэн байна.

**ЗГНХ, ЗДНХ, ангилагдаагүй бусад** орлогод нийт 2,413.2 сая төгрөгийн орлого орсноос, 50.7 сая төгрөг нь боловсролын байгууллагын, 2,362.5 сая төгрөг нь орон нутгийн төсвийн байгууллагуудын орлого байна. Үүнээс: 663.9 сая төгрөг нь байгаль хамгаалах арга хэмжээний санхүүжилт, 293.5 сая төгрөг нь ахмад, хүүхдийн автобусны санхүүжилт, 195.6 сая төгрөг нь замын арчилгаа, тэмдэглэгээнд, нийтийн биеийн тамир, соёл урлагийн арга хэмжээнд 128.7 сая төгрөг тус тус зарцуулагдсан байна.

Орон нутгаас олгосон нэмэлт санхүүжилтийг төсвийн 27 байгууллага, төсөл сангийн тайлан дээр байгууллага хоорондын тооцоо үүсгэж, давхардсан ажил гүйлгээний дүнгээр нийт 2,145.2 сая төгрөгийн устгах бичилт хийсэн. Мөн 444.0 сая төгрөгийн ажил гүйлгээг улсын төсвийн байгууллага буюу ЗГ-ын нөөц сантай хоорондын тооцоо тус тус үүсгэсэн байна.

**Дээд шатны төсвийн захирагчаас хуваарилсан орлого:** Дээд шатны төсөв захирагчаас хуваарилсан нийт 56 байгууллагад 888.1 сая төгрөгийн санхүүжилт хийгдсэн, үүнээс орон нутгийн төсвийн байгууллагын орлого 99.7 сая төгрөг, боловсролын салбарын байгууллагуудын орлого 295.7 сая төгрөг, эрүүл мэндийн байгууллагад 124.9 сая төгрөг, 367.8 сая төгрөг нь ГБХЗХГ-ын Залуучууд хөгжлийн хөтөлбөрийн санхүүжилт байна.

Дээрх ажил гүйлгээг төсвийн байгууллагууд хоорондын тооцоо үүсгэж баталгаажуулж орон нутгийн нэгтгэсэн тайланд 404.2 сая төгрөгийн ажил гүйлгээнд устгах бичилт хийгдэж, 483.8 сая төгрөгийн ажил гүйлгээг бусад ТЕЗ болон харьяа яам агентлагуудтай тооцоо үүсгэсэн байна.

**Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого:**

Нийт 2,378.4 сая төгрөгийн орлого төвлөрүүлснээс 1,848.1 сая төгрөг нь түрээсийн орон сууцны төлбөр бөгөөд Өмчийн харилцааны газрын нэмэлт дансаар дамжуулан Хөгжлийн банканд төвлөрүүлсэн төлбөр, 318.2 сая төгрөг нь Жаргалант сумын нэгдсэн уурын зууханд төлж буй байгууллагуудын халаалтын төлбөр, 20.1 сая төгрөг нь ерөнхий боловсролын сургуулиудын түрээсийн сурах бичгийн үнийг нэмэлт дансаар дамжуулан Боловсрол шинжлэх ухааны яаманд төвлөрүүлсэн орлого, 195.0 сая төгрөг нь орон нутгийн төсвийн байгууллагуудаас бүрдүүлсэн орлого байна.

**Нэмэлт санхүүжилтийн зардлын гүйцэтгэл:** Тайлант онд нэмэлт санхүүжилтийн данснаас 5,660.6 сая төгрөгийг зарцуулж, 230.2 сая төгрөгийг орон нутгийн төсөвт, 39.2 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Зардлын гүйцэтгэлийг өмнөх онтой харьцуулахад дараах байдалтай байна. /сая.төгрөг/

№	Зардлын төрөл	2020 он	2021 он	Зөрүү
		1	2	3=1-2
1	Цалин хөлс, НДШ-ийн зардал	512.70	570.20	(57.50)
2	Байр ашиглалтын зардал	107.00	310.80	(203.80)
3	Хангамж, бараа материалын зардал	228.00	417.70	(189.70)
4	Норматив зардал	42.80	62.50	(19.70)
5	Урсгал засвар, эд хогшлын зардал	209.70	379.10	(169.40)
6	Томилолтын зардал	19.40	4.50	14.90
7	Бусдаар гүйцэтгүүлсэн АҮТХ	2,128.70	1,480.40	648.30
8	Бараа үйлчилгээний бусад зардал	1,922.00	1,997.30	(75.30)
9	Тэтгэмж урамшууллын зардал	888.10	243.40	644.70
10	Хөрөнгийн зардал	92.80	194.70	(101.90)
	<b>Нийт дүн</b>	<b>6,151.20</b>	<b>5,660.60</b>	<b>490.60</b>

Цалин хөлс, НДШ-ийн зардал өмнөх онд 512.7 сая төгрөг байсан бол тайлант онд 57.5 сая төгрөгөөр нэмэгдэж 570.2 сая төгрөг болсон, байр ашиглалттай холбоотой зардал 203.8 сая төгрөгөөр нэмэгдэж 310.8 сая төгрөг, хангамж бараа материалын зардал 189.7 сая төгрөгөөр нэмэгдэж 417.7 сая төгрөг, норматив зардал 19.7 сая төгрөгөөр нэмэгдэж 62.5 сая төгрөг, урсгал засварын зардал 169.4 сая төгрөгөөр нэмэгдэж 379.1 сая төгрөг, бараа үйлчилгээний бусад зардал 75.3 сая төгрөгөөр нэмэгдэж 1,997.3 сая төгрөг, хөрөнгийн зардал 101.9 сая төгрөгөөр нэмэгдэж 194.7 сая төгрөг болж зардлууд өссөн байна.

Харин томилолтын зардал 14.9 сая төгрөгөөр буурч 4.5 сая төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал 648.3 сая төгрөгөөр буурч 1,480.4 сая төгрөг, тэтгэмж урамшууллын зардал 644.7 сая төгрөгөөр буурч 243.4 сая төгрөг болжээ.

## ОРХОН АЙМГИЙН 2021 ОНЫ ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

**АУДИТЫН ДҮГНЭЛТ:**

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:


- Сангийн яамнаас хянасан орлого зарлагын дүнгээс орлогыг 2,117.2 сая төгрөгөөр бууруулж, зарлагыг 5,308.2 сая төгрөгөөр нэмэгдүүлж орон нутгийн төсвийг баталжээ.
- Төсөвт 2 удаа тодотгол хийж хөрөнгө оруулалтын зардлыг 5,011.0 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн.
- Орон нутгийн татварын орлого 9,939.8 сая төгрөгөөр давж биелсэн бол бусад орлого 194.0 сая төгрөгөөр тасарсан байна.
- Тусгай шилжүүлгийн байгууллагын тогтмол зардлыг өмнөх оны гүйцэтгэлтэй уялдуулан бодитой төлөвлөж байх зөвлөмж хүргүүлсэн боловч хэрэгжилт хангагдаагүй, төрийн сангийн гүйлгээг бөөн дүнгээр хянаснаас шалтгаалж нэг ижил дүнтэй гүйлгээ 2 давхардаж гарсан.
- Аймгийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний биелэлт 97.4 хувийн биелэлттэй байна.
- 2020 онтой харьцуулахад нэмэлт санхүүжилтийн дансны орлого 485.6 сая, зардал 490.6 сая төгрөгөөр тус тус буурсан байна.

**ЗӨВЛӨМЖ**

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг холбогдох албан тушаалтанд зөвлөж байна.

Аймгийн Засаг дарга, Төсвийн ерөнхийлөн захирагч С.Батжаргал, аймгийн ЗДТГ-ын Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга Н.Бямбацэцэг нарт:

- Төрийн сангаар хийгдэж буй зарлагын гүйлгээг ижил дүн, утгатай эсэхийг нягталж хянасны дараа баталгаажуулж байх.

ТАЙЛАН БИЧСЭН:  
 АУДИТОР:  Т.БОЛОРМАА  
 6117143890  
 САА0073 9342806